

“ӨМНӨ ЗҮҮН ГОВЬ” ХХК



**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ ГОРХИ-ТЭРЭЛЖ
БЦГ-Т БАЙРЛАХ “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ”
ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

РД: 6054331

УЛААНБААТАР ХОТ 2023 ОН

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	4
1.2 Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил	8
1.3 Төслийн орчны нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин	10
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
2.1 Цаг уур	12
2.2 Агаарын чанар.....	12
2.3 Гадаргын болон гүний ус	15
5.2 Төслөөс усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ	15
Төсөл хэрэгжих орчны гидрогеологийн нөхцөл	16
2.4 Хөрсөн бүрхэвч	20
2.5 Ургамлан нөмрөг.....	23
2.6 Амьтны аймаг	25
Төсөл хэрэгжих орчны амьтны аймгийн зүйлийн бүрдэл, тоо толгой, тархац	25
Төслөөс амьтны аймагт нөлөөлөх байдал үнэлгээ	25
Амьтны аймаг үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах	26
2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг.....	26
2.9 Нийгэмд эдийн засаг	27
Налайх дүүргийн газар нутаг	27
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	29
3.1 Төслийн барилга байгууламжийг өргөтгөн барьж байгуулах үеийн гол нөлөөлөл ..	31
3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл	32
3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	32
3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	34
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл.....	34
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл.....	35
3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл.....	36
3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	36
3.9 Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл.....	37
3.10 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	39

3.11 Хуримтлагдах нөлөөлөл.....	40
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	42
1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.....	43
2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	46
3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	48
4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	48
5. 2023 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	49
6. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	51
7. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧ БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	52

ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн 5.2 га талбайн захын цэгүүдийн солбицол.....	7
Хүснэгт 1. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил.....	12
Хүснэгт 2. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн.....	14
Хүснэгт 3. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн.....	14
Хүснэгт 4. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн.....	14
Хүснэгт 26. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл.....	21
Хүснэгт 27. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт.....	21
Хүснэгт 28. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	22
Хүснэгт 29. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар.....	22
Хүснэгт 30. Хөрсөн дэх хүнд металлын агууламж.....	22
Хүснэгт 13. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа.....	29
Хүснэгт 14. Гол нөлөөллийн дүн шинжилгээ.....	29
Хүснэгт 15. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ.....	33
Хүснэгт 16. Автомашины утааны бүрдэл найрлага.....	33
Хүснэгт 31. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	37
Хүснэгт 18. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл.....	40
Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тайлангах хуваарь.....	52

ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Төслийн байршил.....	8
Зураг 11. Усны нөөцийн сав, Цахилгаан тоолуурын самбар, Ус халаагч бойлероор шийднэ	9
Зураг 14. Горхи-Тэрэлжийн БЦГ-ын голын сав газар.....	15
Зураг 15. Төслийн талбай нь Туул голоос 1.1 км.....	16

<i>Зураг 1. Туул голын ус зүй</i>	19
<i>Зураг 12. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж</i>	20
<i>Зураг 23. Хөхтөн амьтад</i>	25
<i>Зураг 27. Улаанбаатар хотын засаг захиргааны зураг</i>	27
<i>Зураг 4. Улаанбаатар хотын газар ашиглалт</i>	28

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл






“Өмнө зүүн говь” ХХК-нд Улаанбаатар хотын Налайх дүүргийн Горхи-Тэрэлж БЦГ-ын Өвөр хүүшийн аманд байрлах 5.2 га талбайг аялал жуулчлалын зориулалтаар БОНХАЖЯ (хуучин нэрээр) Улсын тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах 2016/264 дугаартай газрын гэрчилгээг 2016 оны 06-р сарын 03-ны өдөр 5 жилийн хугацаатай олгосон байна.

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	“Өмнө зүүн говь” ХХК РД: 6054331
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн байршил	УБ хот, Сонгино хайрхан дүүрэг, 11-р хороо, мандал13, 234б Утас: 99190335
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	Аялал жуулчлалын цогцолбор байгуулах
2.2	Төслийн байршил	<p>Налайх дүүргийн нутагт Горхи-Тэрэлж БЦГ-ын хязгаарлалтын бүсэд аялал жуулчлалын зориулалтаар авсан 52000м2 газарт шинээр хэрэгжинэ.</p> 
2.3	Төслийн зорилго	Төсөл хэрэгжих газрын байршил, байгалийн нөхцлийн давуу талд тулгуурлан үйл ажиллагаа явуулан, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн ая тухтай, тохилог үйлчилгээ бүхий эко Аялал жуулчлалын цогцолбор байгуулна.

<p align="center">2.4</p>	<p align="center">Төслийн ерөнхий төлөвлөгөө</p>	
<p align="center">2.4</p>	<p align="center">Төслийн хүчин чадал</p>	<p>Аялал жуулчлалын цогцолбор нь орчин үеийн шийдэл бүхий 250 хүний даацтай ба 52000м² хамарна. Тус цогцолборын байгууламж нь 25ш амралтын гэр, 15ш амралтын байр, 1ш Үйлчилгээний байр, гэр зоогийн газар, төвлөрсөн ариун цэврийн байгууламж, хүүхдийн тоглоом болон спортын талбай, машин зогсоол зэрэг багтана.</p> <p><i>Ажиллах хүч:</i> Зочин угтах-3, Өрөө үйлчилгээ-5, Аж ахуй-3, Ресторан-6, Гал тогоо-6, Удирдлага-4. Нийт 27 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.</p>
<p align="center">2.5</p>	<p align="center">Төслийн хог хаягдал</p>	<p>Хатуу хог хаягдал:</p> <p>Хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 35.1кг, жилд 5.05 тн орчим хаягдал гарах бөгөөд харъяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-гэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна.</p> <p align="center">Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.</p> <ul style="list-style-type: none"> ✚ <i>Дахин ашиглах боломжтой хог хаягдал:</i> Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт ✚ <i>Бусад хог хаягдал:</i> Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд ✚ <i>Ахуйн аюултай хог хаягдал:</i> Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/

		<p>цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.</p>  <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Шингэн хог хаягдлын тооцоогоор хоногт 8.56 м3, жилд нийт хэрэглэх усны хэмжээ 3 124.4 м3/жил, үүнээс 70%-ийг хаягдал ус гэж үзвэл 2 187.08 м3/жил болно.</p> <p>Бага оврын цэвэрлэх байгууламж</p> <p>“Эколос” ХХК-ийн ОХУ-ын компани болох “Юнилосс” ХХК-ийн оруулж ирдэг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий “Топас” бага оврын цэвэрлэх байгууламж нь 3 хүнийхээс эхлээд 200 хүний хүчин чадалтай 100 гаруй төрлийн бага оврын бохирын станцууд суурилуулж байна.</p>  <p>Хийн хаягдал:</p> <p>Баазын хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.</p>
<p>2.6</p>	<p>Ариун цэврийн байгууламж</p>	<p>Аялал жуулчлалын цогцолбор дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай бөгөөд байгаль орчинтой зөв зохистой харьцах тухай санамжуудыг байрлуулж ба экологийн боловсролын хэсэг, булантай бий болгоно.</p>

“Өмнө зүүн говь” ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь
Горхи-Тэрэлж БЦГ-т “Аялал жуулчлалын цогцолбор байгуулах” төслийн 2023 оны
байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

2.7	Усан хангамж	<ul style="list-style-type: none">  Амралтын газрын цэвэр усны хангамжийг өөрийн гүний худгийг мэргэжлийн компаниар гаргуулан хангана.  Төсөл хэрэгжүүлэх компани нь Усны тухай хуулийн 28.6, 28.11 дэх заалт, 29 дүгээр зүйлд заасны дагуу ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг авч, ус ашиглах гэрээ байгуулан ажиллана.
2.8	Цахилгаан хангамж	<ul style="list-style-type: none">  Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний “ia°ð õ;çáýëèí øöâàìààñ òðàíñòíðìàòòðð байгуулсны үндсэн дээр эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.  Зориулалт бүхий шонгуудыг газарт суулган бэхэлж, цахилгааны утас татах, дэд станц байрлуулах, цахилгааны шугамын гадна ба дотор талын холболтын ажлыг тусгайлсан зураг гаргаж, мэргэжлийн хүмүүсээр өндөр түвшинд гүйцэтгүүлнэ.
2.9	Дулаан хангамж	<ul style="list-style-type: none">  Усан бойлер болон газрын гүний дулааныг ашигладаг орчин үеийн технологийг нэвтрүүлэх шаардлагатай болно.

Хүснэгт 1. Төслийн 5.2 га талбайн захын цэгүүдийн солбицол

Цэгийн дугаар	X	Y
1	107 25 59.361	47 51 17.107
2	107 25 59.638	47 51 20.477
3	107 26 14.278	47 51 20.107
4	107 26 18.216	47 51 22.132
5	107 26 17.626	47 51 18.611
6	107 26 22.461	47 51 15.879
7	107 26 23.838	47 51 16.592
8	107 26 28.215	47 51 12.597
9	107 26 24.627	47 51 12.362
10	107 26 21.491	47 51 13.744
11	107 26 19.688	47 51 13.209
12	107 26 18.846	47 51 14.590
13	107 26 22.301	47 51 15.462
14	107 26 17.435	47 51 18.256
15	107 26 15.861	47 51 9.796
16	107 26 12.737	47 51 9.862
17	107 26 14.224	47 51 19.543
18	107 26 4.453	47 51 19.750
19	107 26 4.347	47 51 16.958

Зураг 1. Төслийн байршил



Төслийн хүрээнд эко аялалыг гол түлхүүр болгон хөгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд Спорт-адал явдлын аялал, Ногоон аялал, Соёлын аялал, Ухамсартай аялал жуулчлал гэсэн төрлүүд багтаж байна.

1.2 Төсөл хэрэгжих орчны газар ашиглалт, дэд бүтцийн хөгжил

Цахилгаан хангамж: Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний өндөр хүчдэлийн шугамаас трансформатор байгуулсны үндсэн дээр цахилгааны эх үүсвэр авч цогцолборын шаардагдах газрууд руу далд холболтоор хүргэснээр өдөр тутмын цахилгаанаар хангана.

Амралтын байрны доторх цахилгаан холболтыг орос, германы монгол улсын стандарт болон ISO 9002 стандартын шаардлага хангасан техник тоног төхөөрөмжөөр холбож тоноглоно. Цогцолборын хашаанд 25-50 гэрлийн шон, харуулын байранд прожекторыг тус тус байрлуулж гэрэлтүүлнэ. Мөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг давхар ашиглахаар төлөвлөж байна.

Тус төслийн хүрээнд эрчим хүч татуулахдаа дараах нөхцөлүүдийг бүрэн хангасан байх шаардлагатай. Үүнд:

Харьяа Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр ирж цахилгаан хангамжийн 220В, 0.4 кВ түүнээс дээш хүчдэлийн сүлжээнд шинээр холбогдох өргөдлийг бөглөж, түүнд заагдсан бүрдүүлэх материалыг “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвд бүрдүүлэн өгч бүртгүүлнэ.

- Өргөдөл
- Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
- Газрын гэрчилгээ,
- Газрын байршлын кадастрын зураг,

- Архитектур төлөвлөлтийн даалгавар, эх зураг гэх мэт-г бэлтгэнэ. Тодруулах хуудсыг үнэн зөв бүрэн бөглөсөн байх шаардлагатай.
Өргөдлийг хүлээн авснаар аж ахуй нэгж байгууллага нь нэмэлтээр шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлнэ. Үүнд:

№	380В	220В
1	Техникийн нөхцөл	Техникийн нөхцөл
2	Холболтын протокол	Газардуулгын протокол /Орон сууцны болон ерөнхий шитнээс холбогдсон бол шаардлагагүй/
3	Газардуулгын протокол	Тоолуурын гэрчилгээ
4	Тоолуурын гэрчилгээ	Байгууллагын гэрчилгээний хуулбар
5	Гүйдэл, хүчдэлийн трансформаторын гэрчилгээ	Харилцах утасны дугаар
6	Газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар	Газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар
7	Байгууллагын гэрчилгээний хуулбар	
8	Харилцах утасны дугаар	

Дулаан хангамж: Цахилгаанаар халдаг панелин пааран халаагуур ашиглана.



Зураг 2. Усны нөөцийн сав, Цахилгаан тоолуурын самбар, Ус халаагч бойлероор шийднэ

Замын тэмдэгжүүлэлт: Автомашины тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу шаардлагатай байршилд суурилуулах шаардлагатай.

Хаягдал бохир усны шийдэл:

“Эколос” ХХК-ийн ОХУ-ын компани болох “Юнилосс” ХХК-ийн оруулж ирдэг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий “Топас” бага оврын цэвэрлэх байгууламж нь 3 хүнийхээс эхлээд 300 хүний хүчин чадалтай 100 гаруй төрлийн бага оврын бохирын станцууд суурилуулж байна.



Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага.” (MNS 6426:2013) стандартын 5.6.4-т зааснаар эко байр сууцны үйлчилгээнд энгийн нүхэн жорлонг ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий био жорлонтой байна.

Автомашин болон явган хүний зам: Тус аялал жуулчлалын цогцолбор нь Горхи Тэрэлжийн БЦГ-т байрлах тул зам харилцаа сайн хөгжсөн юм.

Харилцаа холбоо: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь үүрэн телефоны бүхий л сүлжээ ашиглах боломжтой бөгөөд үйл ажиллагаандаа дотоод сүлжээгээр барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын системийг ашиглана. Төсөлд агааржуулалт, кабелийн телевиз зэргийг хамруулж иж бүрэн автомат сүлжээ бий болгоно. Мөн цогцолборын удирдлагын системд зориулан ажиллагсадтайгаа холбогдох явуулын станцыг суурилуулна.

1.3 Төслийн орчны нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин

Налайх дүүрэг нь Баянзүрх дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумтай хиллэдэг ба засаг захиргааны нэгж 7 хороо бүхий 68,7 мянган га талбай нутаг дэвсгэр, 8992 өрхийн 32513 хүн амтай, 40568 малтай. Нийслэл хоттой авто болон төмөр замаар холбогдсон.

Төрийн төсөвт 28 байгууллагатай, ерөнхий боловсролын сургуульд 6000 гаруй сурагч, Мэргэжлийн Сургалт Үйлдвэрийн Төвд 1200 гаруй хүүхэд, цэцэрлэгт 1126 хүүхэд тус тус суралцдаг. 120000, 45000 квт-ийн хос шугамаар Улаанбаатартай холбогдсон, эрчим хүчний хэрэглээг 10 дахин нэмэгдүүлэх чадалтай өртөөтэй.

Нийслэлийг цэвэр усаар хангаж буй дээд эх үүсвэртэй холбогдсон. Дулааны одоогийн хэрэглээг 3 дахин нэмэгдүүлэхэд хангах дулааны станцтай. Цэвэрлэх байгууламжийн хувьд нийслэлтэй холбогдож байгаа.

Уул уурхайн, шилний үйлдвэр, эрчим хүч, авто, оёдлын мэргэшсэн инженер техникийн ажилтан, ажилчдын ажиллах хүчний нөөцтэй. Зүүн аймгууд болон нийслэлийг холбосон уулзвар газар тул хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хүлээн авч боловсруулах үйлдвэр малын зах байгуулах боломжтой.

Налайх дүүрэгт Чингисийн хүрээ, Түрэгийн Тоньюкукийн хөшөө, Хан Хэнтийн Дархан Цаазат Газар, Горхи Тэрэлжийн Байгалийн Цогцолбор Газар зэрэг түүхийн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газар олонтой. Туул голын “Хар шугуйн” Хөх Тэрмэсийн Чингис уулын бэлд “Чингисийн хүрээ” нэртэй газар байдаг.

Одоогоор Налайх дүүрэг Чех, Солонгос, Сингапур, БНХАУ-тай гадаад харилцаатай бөгөөд ойрын хугацаанд Налайх дүүрэгт 3000 айлын иж бүрэн орон сууцны хороолол баригдахаар төлөвлөгдсөн.


Ойрын ирээдүйд Налайх дүүрэг аж үйлдвэрийн шинэ паркттай болж барилгын 40 гаруй дунд, жижиг үйлдвэр ашиглалтанд орсноор, ажлын байр нэмэгдэнэ. Хан Хэнтий, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Хөдөө аж ахуйн талаар эрчимжсэн мал аж ахуйтай, хүнсний ногоо, жимс жимсгэний мод голлон тариалах газар тариаланг хөгжүүлэх боломжтой дүүрэг юм.

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


2.1 Цаг уур

Төсөл хэрэгжих орчимд эх газрын уур амьсгалын онцлогоос болоод жилийн хүйтэн улиралд агаарын температур газар өндөрсөх тутам дулаарах, харин дулаан улиралд газар өндөрсөх тутам сэрүүсдэг байдал энд тодорхой харагдаж байгаа бөгөөд “хотын дулаан арал” тод илэрч байдаг онцлогтой.

Зураг 1. Хур тунадасны үзүүлэлт



Зураг 2. Уур амьсгалын үзүүлэлтүүд




Аливаа төслийн төлөвлөлтөнд тухайн төсөл хэрэгжих орчны байгаль цаг уурын онцлог, уур амьсгалын хүчин зүйлийг судалж, нарийн сайн тооцоолох хэрэгтэй. Харин тус төслийн хувьд хэрэгжих орчин нь эрс тэс уур амьсгалтай, агаарын болон хөрсний температур сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай, тухайн орчны агаарын хуурайшилт эрчимжиж байна. Хавар, намрын улиралд салхины хурд ихэсч, шороон шуургын давтамж нэмэгдэх, салхины нөлөөгөөр ууршилт нэмэгдэж, хуурайшилт эрчимжихийг цаашдын үйл ажиллагааны төлөвлөлтөнд харгалзан үзэх шаардлагатай.

2.2 Агаарын чанар

Төслийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд

Хүснэгт 2. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил

Агаар		Координат	Цэг сонгосон үндэслэл	Дээж авч буй фото зураг
1	1-р цэг	47° 51' 16.91" N 107° 26' 15.83 E	Өмнө хийгдсэн хяналт-шинжилгээний үр дүнтэй харьцуулах	

Судалгааны арга, дээж авалт

Төслийн гадна талбай болон барилгын ажлын талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлт тус бүрийг хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнд тодорхойлов. Үүнд:

- **Хүхэрлэг хий болон Азотын давхар исэл:** Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлсон.
 - **Хүхэрлэг хий:** Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозанаины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлов.
 - **Азотын давхар исэл:** Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргаанд шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфанаины хүчилтэй харилцан үйлчилж диазонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимшлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлов.
- **Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис):** Төслийн талбай орчмын агаарт агуулагдах нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг DustTrak 8530 зөөврийн багажийн тусламжтай тодорхойлсон.
- **Дуу чимээ:** Шуугианы хэмжилтийг MNS 5003:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.” стандарт аргачлалын дагуу EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355) загварын зөөврийн багажаар тодорхойлсон.

Судалгаанд ашигласан багаж хэрэгсэл



Фото зураг 1. DustTrak 8530 загварын зөөврийн багаж



Фото зураг 2. EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355 загварын зөөврийн багаж

Хяналт шинжилгээний үр дүн

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй, хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 3. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/
1	барилгын ажлын талбай	0.101
2	гадна талбай	0.114
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.500

Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 4. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	NO ₂	SO ₂
		(Азотын давхар исэл мг/м ³)	(Хүхэрлэг хий мг/м ³)
1	барилгын ажлын талбай	0.065	0.053
2	гадна талбай	0.076	0.030
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016		0.200	0.450

Дуу шуугианы хэмжилт

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын 2 цэгийн ойр орчимд хэмжсэн ба 16 цагийн дундаж үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад төслийн барилгын ажлын талбайн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна.

Хүснэгт 5. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Сорьц авсан цэг	Дуу чимээ дБ (А)
1	барилгын ажлын талбай	62
2	гадна талбай	54
Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 дБ (А), 16 цагийн дундаж		60

Дүгнэлт, зөвлөмж

Төслийн эзэмшил талбай болон гадна талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад барилгын ажлын талбайд авсан дуу шуугианы хэмжилтийн 16 цагийн дундаж түвшин 62 ДБА байгаа нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2 ДБА-аар их байна.

Шуугиан гэж янз бүрийн давтамжтай өндөр, нам авианы замбараагүй хослолыг хэлнэ. ДЭМБ-аас гаргасан судалгаагаар шуугианы шалтгаантай сонсгол бууралт нь дэлхийд хамгийн түгээмэл тохиолддог, урьдчилан сэргийлэх боломжтой мэргэжлээс шалтгаалсан өвчний нэг гэж үздэг [12].


Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд ногоон байгууламж хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай учир нь модлог ургамал дуу чимээний бохирдлыг бууруулаад

зогсохгүй орчны агаарыг цэвэршүүлэх ач холбогдолтой. Зайлшгүй шаардлагатай биш бол машины дуут дохиог хэрэглэхгүй байхыг ажилчдад анхааруулах.

2.3 Гадаргын болон гүний ус

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь гадаргын усны сүлжээний хувьд Туул гол болон Тэрэлж гол түүний цутгал голууд хамаарагдана. Туул гол Тэрэлжийн гүүр орчмоор, Тэрэлж голын ус хурах талбай нийтдээ, мөн томоохон голуудаас Заан тэрэлж гол, Баруунбаян гол, Хаг, Галттай голуудын адаг хэсэг хамрагдаж байна. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь Туул голын сав газрын 5.85 хувийг эзэлнэ. Голуудын сүлжээний нягтшил ихтэй. Эдгээр голууд нь хойд мөсөн далайн ай савд хамаарагдана.

Зураг 3. Горхи-Тэрэлжийн БЦГ-ын голын сав газар



5.2 Төслөөс усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

Уг төсөл нь гадаргын усыг ашигладаггүй зөвхөн газрын гүний усыг ашиглах болно. Хаягдал бохир усыг “Эколос” ХХК-ийн ОХУ-ын компани болох “Юнилосс” ХХК-ийн оруулж ирдэг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий “Топас” бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулах зөвлөмж орууллаа. Төслийн талбай нь Туул голоос 1.1 км зайтай байрладаг байна.

Зураг 4. Төслийн талбай нь Туул голоос 1.1 км



Төсөл хэрэгжих орчны гидрогеологийн нөхцөл

Улаанбаатар хотын районы хэмжээнд дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд агуулагдсан дөрвөн уст горизонт, үндсэн чулуулгийн ан цав, нүх сүв, гүний хагарлуудын дагуух сурлалын бүстэй холбоотой агуулагдсан дөрвөн уст комплекс бий.

Улсын нийслэл Улаанбаатар хот, түүний ойр тойрон нь гидрогеологийн хувьд Улаанбаатарын газрын доорх усны ай савд хамаарна. Улаанбаатарын ойр тойронд геологийн өөр өөр насны чулуулаг доторх устай хэд хэдэн бүрдэл, бүстэй холбоотойгоор даралтгүй чөлөөт гадаргатай болон даралттай ус, рашаан зэрэг газрын доорх усны нэлээд олон төрөл тархсан нь Улаанбаатарын газрын доорх усны ай сав гэж ялгах үндэслэл болж байгаа юм. Улаанбаатар хот, түүний оршин байгаа Улаанбаатарын газрын доорх усны ай сав нь анх В.А. Обручев 1898, 1900 онд геологийн судалгааны явцад гидрогеологийн ажиглалт явуулж, газрын доорх усны судалгааг эхэлж байснаас хойш Орос-Монголын олон гидрогеологичид олон жилийн хүч хөдөлмөрөөр гидрогеологийн хувьд Монгол орны хэмжээнд сайн судлагдсан газар нутагт хамрагдана.

Улаанбаатарын газрын доорхи усны ай сав уулс хоорондын артезийн ай сав бөгөөд хойт талаараа Чингэлтэй нуруу, урд талаараа Богд уул, зүүн, баруун талаараа Баян Зүрх, Сонгинын уулсаар хүрээлэгдсэн байдаг, гадаргын болон газрын доорхи усны өвөрмөц холбоог үүсгэдэг бэсрэг хэмжээтэй боловч усны харьцангуй арвин нөөцтэй. Энэхүү ай савд Хойт Туулын, Урд Туулын гэсэн 2 томоохон региональ хагарал байдгийг геологичид зураглан тогтоосон байдаг. Уг ай савыг хүрээлэн байгаа уулс нь газрын доорхи усны тэжээлийн бүс, Улаанбаатарын хотгор нь хуримтлал, зөөгдөл, хөлийн бүс болдог. Улаанбаатарын уулс хоорондын артезийн ай сав хэмжээнд палеозой, доод цэрд, неоген,

дөрөвдөгчийн хурдасны устай бүрдлүүд, устай тектоникийн ан цавын бүс тус тус тархсан байна. Үүнд:

1. Орчин үеийн дөрөвдөгч – дээд дөрөвдөгчийн настай аллювийн хурдас дахь устай бүрдэл.
2. Дээд дөрөвдөгч – дунд дөрөвдөгчийн настай аллювийн хурдас дахь устай бүрдэл.
3. Ангилагдаагүй дөрөвдөгчийн настай аллюви – пролювийн хурдас дахь устай бүрдэл.
4. Неогений настай эх газрын гаралтай сэвсгэрдүү хурдас дахь устай бүрдэл.
5. Цэрдийн настай эх газар – нуурын гаралтай сэвсгэрдүү хурдас дахь устай бүрдэл.
6. Палеозойн настай, метаморфижсан тунамал чулуулаг дахь газрын доорхи устай ан цавлаш бүс.

Орчин үеийн дөрөвдөгчийн аллюви, пролювийн уст горизонтнуудын: (ар QIV) талбайн хэмжээнд хамгийн томд орох Туул голын хөндий түүнд салбарлаж нийлдэг Толгойт, Сэлбэ, Улиастай голуудын цутгалын хэсэг хамаарагдана. Уст үеийн ерөнхий зузаан 50-60 м татмын өндөр дэнжийн орчимд 5-10 м орчим болдог. Грунт ус нь зуны улиралд газрын гадаргуугаас 0.5-4.0 метрийн гүнд 1245-1320 метр ийн үнэмлэхүй өндөрт харгалзах түвшинд илэрдэг. Урсгалын ерөнхий чиглэл нь голын хөндийн дагуу зүүнээсээ баруун тийшээ чиглэлтэй, гадаргуугийн налуу нь Амгалангийн суурины районд 0.004 байна. Уст горизонтын тэжээгдлийн гол эх үүсвэр нь Туул голын ус бөгөөд баруун эргээс цутгаж буй Толгойт, Сэлбэ, Улиастай голуудын ус ба агаарын хур тунадас нэмэгдэх байдлаар тэжээж чөлөөт гадаргуутай оршино. Өвөл хаврын улиралд усажсан хагарлуудын ан цав-судлын ус болон уст комплексуудын ан цавын усаар тэжээгддэг. Ус агуулагч хурдас нь бул чулуу агуулсан сайр, сайрга, жижиг ба дунд зэргийн ширхэгтэй элс, бага зэрэг элсэнцэр, шавранцраар чигжигдсэн, шаварлаг хөрсний нарийн үеүд агуулна. Уст горизонтын доод хил (водоупор) нь неогены настай улаан өнгийн шавар болно. Грунт усны тогтонги ундарга $Q=0.16-53.3$ л/с, түвшний бууралт $S=0.65-12.7$ м үед хувийн ундарга $q=0.10-28.7$ л/сек болно.

Дунд, дээд дөрөвдөгчийн орчин үеийн аллюви, пролюви, делюви-пролювийн хурдасны уст горизонтод Туул голын хөндийд салбарлаж байгаа Толгойт, Сэлбэ, Улиастай, Залаатын ам, Яармагийн дэнж орчмын хэсэг хамаарагдана. Ус агуулагч хурдас чулуулаг нь жижиг дунд ширхэгтэй элс, элсэнцэр, шавранцраар чигжигдсэн сайр, сайрга, жижиг бул чулуутай хөрс зонхилно. Уг хурдасны дунд элс шаварлаг хөрсний нарийн үеүд, олон жилийн цэвдэг хөрс тохиолдох онцлогтой. Грунт усны урсгалын чиглэл нь хойноосоо урагшаа чигтэй, гадаргуугийн налуу 0.001-0.003 хүрнэ.

Дунд-дээд дөрөвдөгчийн аллюви-пролюви, делюви-гляциалын хурдасны уст горизонт (QII - IV) нь талбайн зүүн өмнөд хэсэг Хүрхрээгийн ам, Яармагийн орчим, уулархаг рельефийн хормойн хэсгээр бага талбайд тархсан онцлогтой. Тэжээгдлийн эх үүсвэр нь агаарын хур тунадас, түр зуурын урсгал ус болно. Энэ горизонтын талаар судалгааны материал бага, тархалт нэлээд талбайг хамаарна.

Ангиллагдаагүй дөрөвдөгчийн элюви- делювийн хурдасны уст горизонт (Q) нь талбайн баруун урд, нисэх буудлын район, зүүн хойд хэсэгт тархсан. Зарим тохиолдолд бага зузаантай орчин үеийн дөрөвдөгчийн хурдасны доороос илэрдэг. Уст горизонт нь зузаан багатай (2-4м). Ихэвчлэн үндсэн чулуулгийн өгөршлийн үе, шаварлаг хөрсний элсэрхэг

нарийн үеүдэд тодорхой зүй тогтолгүй ”өлгөмөл” байрлалтай оршино. Тэжээгдлийн эх үүсвэр нь ан цавын гаралтай булгуудын ус бөгөөд агаарын хур тунадасны ус улирлын чанартай нөлөөлдөг. Мөн түүнчлэн энэхүү өлгөмөл ус нь хүний инженерийн үйл ажиллагааны улмаас ”техногени” гаралтай алдагдал усаар нэмэгдэл тэжээл авах бүрэн боломжтой. Судалгааны материалуудаас үзэхэд грунт ус 0.2-8.0м-ийн гүнээс илэрдэг бөгөөд ус агуулагч чулуулгийн шүүрэлтийн коэффициент бага учир түвшин нь аажимдаа тогтворждог байна.

Неогены нуур-аллюви-пролювийн хурдасны уст комплекс (N) нь Улаанбаатарын районы төвийн хойд хэсэгт III–IV хороолол, Шар хадны баруун хэсэгт толболог байдалтай тархсан. Ус агуулагч хурдас нь бор шаргал, улаавтар өнгөтэй хайргархаг, сайргархаг хэмхдэс материал янз бүрийн хэмжээгээр агуулсан шавар, шавранцар зонхилно. Ихэнх тохиолдолд шавар хөрсний үе хоорондын байдалтай оршдог, ус агуулагч хурдасны ус нэвтрүүлэх шинж чанараас хамаарч ундарга багатай. Уг уст комплексын тархсан талбай нь их хэмжээгээр барилгажин, ус дамжуулах байгууламж нягт төвлөрч байгаа нь грунт ус бохирдох, түвшин нь дээшлэх үзэгдэл үйл явц хөгжих бүрэн боломжтой юм.

Доод цэрдийн нуурын хурдасны усны комплекс (K1) талбайн баруун хойд хэсэгт XXI хорооллын зүүн талд зурвас байдлаар тархсан. Ус агуулагч хурдас нь ногоон саарал өнгийн шавранцар янз бүрийн хэмхдэс агуулсан заримдаа конгломератын нарийн үетэй болно. Уг комплексын дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар хучигдсан хэсэгт (Туулын хөндийн) уст горизонт 34-42м-ийн гүнээс хэдэн арван метрийн зузаантай илрэх бөгөөд ус нь нэлээд эрдэсэжсэнээрээ ялгагдана. Харин гадаргуу нь ил гарсан хэсэг болох I хороолол, Тоосгон завод, Ханын материалын комбинатын орчинд хэсэгчилсэн тархалттай ”өлгөмөл” ус байдалтай ангилагдана. Энэ газар доорх усны ундарга $Q=0.2-0.9$ л/с орчим байна. Тус районд ус их хэрэглэдэг үйлдвэрийн газрууд хэд хэд байршсантай уялдаж алдагдал ус (техногены) үүсч үндсэн горизонтын тэжээлийг ихэсгэх нэг нөхцөлийг бүрдүүлж байна.

Палеозойн тунамал чулуулгийн уст комплекс (C1) нь Туул голын хөндийн дагуу толболог байдалтай тархсан. Ус агуулагч чулуулаг нь ан цавархаг үелэг тогтоцтой алевролит, аргиллит, шаварлаг занар бага зэрэг элсэн чулуу болно. Өмнөх судалгааны материалаас үзэхэд уг ус нь газрын гадаргаас 34-70м-ийн гүнд тохиолдох бөгөөд зарим тохиолдолд рельефийн нам хэсгээр булаг байдлаар илэрнэ. Зарим нэг цооногийн өгөгдлөөр ундарга нь 1.0-2.0 л/с болно.

Юрагийн интрузив чулуулгийн уст комплекс (J) нь талбайн зүүн урьд хэсэгт бага талбайд илэрдэг. Уг уст комплекс бараг судлагдаагүй. Улаанбаатар хотын инженер геологийн зураглалын ажлаар Хүрхрээгийн ам, Залаатын амны булгууд нь интрузив чулуулгийн нүх сүвний байрлалтай уст комплекстой холбоогүй гэж үзсэн байна.


Грунт усны түвшний хэлбэлзэл. Грунт усны түвшний хэлбэлзэл нь уст горизонт тус бүр дээр өөр өөр байна. түвшний хэлбэлзлийг ажиглах зориулалттай 1200 гаруй цооногийн материалыг үзэхэд 1954-64 оны үед ерөнхий түвшин (усан хангамжийн бүсүүдэд) 2.0м, Улиастай голын цутгалын орчимд 0.5м-ээр тус тус буурсныг тогтоосон байна. Одоогийн байдлаар өвөл хаврын улиралд усан хангамжийн зориулалттай цооногуудын 0.5-14км-ийн радиусын зайд 7-13м хүртэл, дулааны улиралд (хур бороо элбэг үед) 4-5м орчимд хэлбэлзэлтэйгээр буурсан байна. Бусад талбайд ихэнх тохиолдолд 0.80-3.0м хүртэл

хэлбэлздэг. Түвшний хэлбэлзлийн хамгийн их утга YIII-IX саруудад, хамгийн бага утга III - IV саруудад ажиглагдана.

Улаанбаатарын орчимд тархсан Туул голын хөндий нь газрын доорхи усны тэжээгдэл, хуримтлал, хөлийн бүс болж, Чингэлтэй, Баянзүрх, Богд Сонгино Хайрхан уулс нь газрын доорхи усны тэжээгдлийн бүс болж уулархаг хэсэгт үүссэн динамик нөөц Туулын хөндий дэх газрын доорхи усаа тэжээдэг тал бас бий.

Төслийн талбай нь Дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Монгол орны 29 голын сав газрын Туул гол болон Хараа голын сав газарт хамаарагддаг. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадаргын усан сүлжээ нэлээд сайн хөгжсөн байдаг. Тухайлбал, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамгийн том гадаргын усан сүлжээний илэрц нь Туул гол юм.

Туул голын тэжээлийн 25%-ийг ул хөрсний ус, 6%-ийг хайлсан цасны ус, 69%-ийг хур борооны ус эзлэх ба усны горимын хэв шинж нь хаврын шар усны ба зуны хур борооны үеийн горимтой голд хамаарна. Туул голын урсац бүрдүүлэх үндсэн хүчин зүйл бол хур тунадас болно. Туул голын усны үндсэн тэжээл зун, намрын хур бороо болохоор усны түвшин ихээхэн тогтворгүй байдаг. 4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч үргэлжлэх хугацаа, урсцын хэмжээгээр бага юм. Хаврын шар усны үерийн дараагаар нэг хэсэгтээ зуны гачиг үе ажиглагдах бөгөөд 7-9 дүгээр сар хүртэл зун, намрын борооны үер залгаснаар голын усны түвшин эрс дээшилнэ.



Зураг 5. Туул голын ус зүй

Борооны үерийн түвшин шар усны үерийн түвшингээс 1.5-2.0 дахин их байдаг. Хур борооны үер дууссаны дараа мөсний үзэгдэл үүсэх хүртэл усны түвшин аажим буурч өвлийн гачиг үе эхэлнэ.

Туул голын сав газарт хамаарах Өвөр хүүшийн голын усны химийн найрлагын үндсэн эх үүсвэр нь голын сав газрын уулын чулуулаг боловч, цэгийн бохирдлын үүсвэрийн нөлөөгөөр давамгайлах ионууд болон ионы харьцаанд ихээхэн өөрчлөлт орж байна. Өвөр хүүшийн голын усны химийн найрлага, бохирдуулагч үзүүлэлтүүдийн хэлбэлзэл, жилийн

доторхи хуваарилалт нь голчлон үндсэн урсац, хайлсан цас, мөс, гадаргын угаагдал, хур борооны усны сүлэгдэл холилдлыг харуулж байгаа боловч, голын ихээр бохирдсон хэсэгт урсацын хэмжээ өөрөөр хэлбэл, голын услагаас шууд шалтгаалдаг байна.

Төслийн талбай орчимд Өвөр хүүшийн гол урсаж байгаа учраас төслийн үйл ажиллагааны улмаас гадаргын усанд нөлөөлөх боломжтой. Төслийн зүгээс гүний усанд үзүүлж болзошгүй нөлөөлөлд усыг барилгын ажил, тоос дарах болон ахуйн зориулалтаар ашигласнаас зэргээс гүний усны түвшин тодорхой хэмжээгээр буурах нөлөөлөлд орно. Гүний болон гадаргын ус нь барилгын болон ашиглалтын шатанд шатахуун тослох материалын алдагдал, хог хаягдалаас бохирдож болзошгүй.


2.4 Хөрсөн бүрхэвч

Энэхүү бүлэгт Улаанбаатар хотын Налайх дүүргийн Горхи-Тэрэлж БЦГ нутгийн Өвөр хүүшийн аманд байрлах 5.2 га аялал жуулчлалын зориулалттай газарт хийсэн хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнг тусгав.

Судалгааны үр дүн

Төсөл хэрэгжих талбай нь газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хамаарна. Тус нэгж талбарт уулын тайгын ширэгт бүдүүн ялзмагт хөрс тархсан байна.


Зураг 6. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж



Зүсэлт №1



Хүснэгт 6. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
Хөрсний зүсэлтийн дугаар	Зүсэлт №1	
Байршил	Улаанбаатар хотын Налайх дүүрэг, 6-р хороо	
Координат	47° 51' 16.845" N	
	107° 26' 15.872" E	
Өндөр	д.т.д 1505 метр	
Газрын гадарга	3°	
Ургамлын бүрхэвч	20%	
Хөрсний нэр	Уулын тайгын ширэгт бүдүүн ялзмагт хөрс	
Хөрсний фото	Гүн	Морфологи шинж чанар
	A. 0-20 20 см	Хархүрэн өнгөтэй, хуурай, нягт, ургамлын үндэс эзлэхүүний 10%, үйрмэг чулуу эзлэхүүний 20%, шилжилт өнгө байна.

Хүснэгт 7. Төслийн талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

Зүсэлт	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс	Ялзмаг, %	Са CO ₂ , %	NO ₃ , мг/100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд, мг/100 гр	
								Са	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	0-20	7.06	0.081	0.027	2.89	0.0	0.12	15.0	10.0	0.4	3.0

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж хэвийн, шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ бага, хялбар уусах давсны агууламж бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор бага, калийн агууламж мөн байгаа нь хөрсний үржил шимийн түвшин ерөнхийдөө бага байгааг илтгэж байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн

хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

Хүснэгт 8. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний нэр	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар						Шавар
		Элс		Тоос				
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	0-20	15.5	29.3	28.9	8.7	4.5	13.1	26.3

Хөрсний шинжилгээний дүнгээр физик шаврын хэмжээ элсэнцэр ба хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй. Энэхүү хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрс нь норж дэвтсэн үедээ хөөж, малын хөлд наалдаж мөр гаргахгүй мөн хуурай үедээ сууж өрөмдөхгүй. Том ширхэгтэй бөгөөд ихэнх тохиолдолд сулхан, тогтворгүй бүтэц үүсгэдэг. Ширхгүүдийн хооронд зай томтой агааржилт сайтай усны хөдөлгөөн ихтэй. Уужим сүвтэй, гадаргадаа бусад биетийг шингээх чадвар султайгаас хур тунадас элбэгтэй жилд ургамлын хооллолтод чухал ач холбогдолтой бодис ба анион, катион хөрсний гүнд угаагдах аюултай. Хөнгөн хөрс шингээлт багатайгаас шим тэжээлийн бодис бага агуулагдах ба байгалийн нөөц үржил шимээр ядуу юм. Хөнгөн хөрс хуурай, агааржилт сайтайгаас хавар эрт бүлээсэж, тэр хэмжээгээрээ эрт ногоо идүүлдэг сайн талтай. Мөн усыг сайн нэвтрүүлдэг (гүндээ дамжуулдаг) учраас гадаргад нь ус тунадаггүй, усаар угаагдаж гуу жалга үүсдэггүй.

Хүснэгт 9. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар

Хөрсний шинж чанарын үзүүлэлт	Механик бүрэлдэхүүн		
	Элсэнцэр ба хөнгөн шавранцар	Дунд шавранцар	Хүнд шавранцар, шавар
1 Боловсруулалт	++	+	- -
2 Тэжээлийн бодис агуулалт	- -	+	++
3 Ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт	-	++	+
4 Хоруу бодисын хуримтлал	-	++	++
5 Ус агуулалт	- -	++	++
6 Ургамал ус нийлүүлэлт	-	+	-
7 Механик шүүлт	+	+	-
8 Физик-химийн шүүлт	- -	++	+
9 Ус шүүлт	++	0	- -

*++ маш сайн (дээд зэрэг), + сайн (өндөр), 0 хангалттай (дунд зэрэг), - тааруу, - - нэн хангалтгүй

Дээрх хүснэгтээс үзэхэд элсэнцэр ба хөнгөн шавранцар хөрс нь тэжээлийн бодис, ус агуулалт болон физик химийн шүүлт нэн хангалтгүй, ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт, хоруу бодисын хуримтлал, ургамлын ус нийлүүлэлтээр тааруу харин механик шүүлт сайн, хөрсний боловсруулалт, ус шүүлтээр маш сайн гэсэн үзүүлэлттэй байна.

Хүнд металлын агууламж

Хүснэгт 10. Хөрсөн дэх хүнд металлын агууламж

Зүсэлтийн дугаар	Хүнд металлын агууламж мг/кг					
	Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Zn /Цайр/	Cr /Хром/	Cu /Зэс/

1	8.4	ND	22.7	18.6	23.5	14.3
Хүлцэх агууламж (MNS 5850 : 2019)	60.0	1.0	50.0	100.0	60.0	60.0
Хортой агууламж (MNS 5850 : 2019)	1000.0	10.0	500.0	600.0	400.0	500.0
Аюултай агууламж (MNS 5850 : 2019)	1800.0	20.0	1200.0	1000.0	1500.0	1000.0

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үзэхэд стандартын хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага байна.

Хөрсний элэгдэл

Төслийн талбайд одоогийн байдлаар ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа.

2.5 Ургамлан нөмрөг

Судалгааны талбай нь ургамалжил-газарзүйн мужлалаар Евро-азийн хээрийн мужийн Дагуур-Монголын хээрийн хошууны Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойргийн Сэргэлэнгийн дүүрэгт багтана (Юнатов, 1950).

Хангай, Хэнтийн уулархаг их муж, Хэнтийн мужийн Хэнтийн нуруу болон түүний гол салбаруудад багтдаг (Цэгмид, 1969).



Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн

Судалгааны талбай нь 16 овгийн 37 төрлийн нийт 46 зүйл ургамал бүртгэгдсэн. Энэхүү ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд

- ❖ Сөөглөг 1
- ❖ Сөөг 5
- ❖ Сөөгөнцөрлөг 2
- ❖ Олон наст өвс 35,
- ❖ Ганц ба хоёр наст 3 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Ургамлын амьдралын хэлбэрээр нь эзэлж байгаа хувиар олон наст өвс 76%, ганц ба хоёр наст 7 сөөг 11% байна.

Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн ургамлан бүрхэвч



Төслийн талбай нь ой модноос 0.07 км зайтай байна. Төсөл хэрэгжих талбайд үетэн-улалж-алаг өвст ургамлын бүлгэмдэл тархсан боловч Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн ургамлын зүйлийн бүлгэмдэл хотжилт, хүн амын хэт төвлөрөл, суурьшил зэргээс шалтгаалж төрөл зүйл, тоо хэмжээ өдрөөс өдөрт буурч байна.

Горхи-Тэрэлжийн раойны Баргын өвөлжөө гэдэг газар нь Евро-Азийн шилмүүст ойн мужийн Өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрогт багтдаг. Энд Шинэс-хус бүхий холимог ойтой. Ургамлын бүлгэмдлийн хувьд алаг өвс-улалж-үетэнт, алаг өвс-үетэнт бүлгэмдэл зонхилж байна.

Нийт 20 овогт хамаарах 38 төрлийн 42 зүйл ургамал бүртгэгдсэн. Зонхилох овгууд нь үетэн, нийлмэл цэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтний овгийн ургамлууд хамаарна. Нэн ховор, ховор ургамал байхгүй. *Juniperus pseudosabina*-Хуурамч хонин арц, *Taraxacum glabrum*-Хүцгэн багваахай, *Valeriana officinalis*-Эмийн бамбай, *Saussurea foliosa*-Навчирхаг банздоо, *Poa Khenteica*- Хэнтийн биелэг өвс, *Festuca Litvinovii*-Литвиновын ботууль, *Thymus roseus*-Ягаан ганга, *Veronica perpusilla*-Жижиг гандбадраа, *Aster Sanczirii*-Санчирын гэсэр зэрэг ургамлууд тархсан.

2.6 Амьтны аймаг

Төсөл хэрэгжих орчны амьтны аймгийн зүйлийн бүрдэл, тоо толгой, тархац

Судалгааны талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн тайгын голлох элемент болох олон зүйлийн хөхтөн амьтдын тархалттай. Хан Хэнтийн дархлагдсан нутгийн хүрээнд 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болоннүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 9 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг.

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх байдал үнэлгээ

Хөхтөн амьтад: Энд монгол орны хөхтөн амьтны 35 хувь буюу 6 баг, 17 овог, 40 төрөлд хамаарах 54 зүйл хөхтөн байгаагийн дотор шинээр нутагшиж буй янгир, америк усны булга ордог.



Зураг 7. Хөхтөн амьтад

1. Ойн амьтад - Цармын атаахай, чандага, хэрэм, жирх, олби, ойн улаан ба хүрэн оготно, ойн хөвхөлжин, шилүүс, гахай, буга, согоо, гөрөөс,
2. Хад асганд амьдрах амьтад - Асганы огодой, хадны барагчин, янгир,
3. Хаана ч тохиолдох амьтад - Саарал чоно, үнэг, цагаан үен гэж ангилна.

Амьдралын төрх байдлын хувьд 4 зүйл сарьсан багваахайнаас бусад нь суурин амьдралтай бөгөөд жирх, тарвага, урт сүүлт зурам, сибир алаг даага, дорго зэрэг цөөн зүйл амьтад ичээлдэг ба бусад зүйлүүд бүх л жилийн турш идэвхтэй амьдралтай юм.

Шувууд: Төслийн талбайд 14 багт хамаарах 36 овгийн 205 зүйлийн шувуу тэмдэглэгдсэнээс суурин 51, нүүдлийн 143 зүйл бий, нүүдлийн шувуу оршин амьдрах хэлбэрийн хувьд өндөглөн зусдаг 47, дайрч өнгөрдөг 59, хааяа тохиолдлоор орж ирдэг 5, зун тааралддаг боловч өндөглөдөг эсэх нь одоогоор тодорхойгүй 18 зүйл байдаг.

Шувуунаас суурин амьдардаг юм уу өндөглөн зусдаг нүүдлийн шувууны гол төлөөлөгч 68 зүйл, байгалийн 5 бүлгэмдэл бүр торшин амьдардаг. Гаднын элдэв нөлөөллөөс болж зарим шувууны үүрлэн өндөглөх, үр төлөө бойжуулах, нуугдан хоргодох, идээшлэх, нүүдлийн үедээ байршин амьдрах тохиромжтой тайван нутаг багассанаас амьдралын хэвийн зохицолдоо алдагдаж, дайжин холдох явдал ихсэх хандлагатай байна. Сүүлийг үед эрс ховордож байгаа 24 зүйл шувуудаас алга болсон хар өрөвтас, хөтүү, усны цагаан сүүлт бүргэд зэрэг шувуудын тархац байршлыг зурагт тусгайлан үзүүлээ.

Шавж: Төслийн талбайд 16 баг 174 овгийн 1660 зүйл шавж амьдардаг. Үүнээс ховордсон 6 зүйлд Апполлон эрвээхэй *Parnassius Apollo*, Ксют дэвүүрээхэй *Sinoprinceps xuthus*, Махаон эрвээхэй *Papilio machaon*, Инжирийн шумбуур *Deilephila elpenor*, Бэр цэцэгч шумбуур *Нemaris tityus*, Модестус үхэр хэдгэнэ *Bombus modestus* зэрэг зүйлүүд орсон байдаг.

Амьтны аймаг үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн ойр орчмын амьтад дайжихаас сэргийлж чанга дуу чимээ гаргахгүй байх. Ажилтан амрагч нар нь ойгоор явахдаа болгоомжтой хандаж ан ав хийхгүй байх.

2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг

